



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 08 сарын 19 өдөр

Дугаар А/389

Арвайхээр

**Коронавируст халдвар (COVID-19)-ын үед
нэмэлтээр ор дэлгэх төлөвлөлтөд тодотгол
хийх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3.5, 10.4.4, 18 дугаар зүйлийн 18.4, 32 дугаар зүйлийн 32.1.9 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн “Коронавируст халдвар (COVID-19)-ын үед эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх зураглал, батлах тухай” А/416 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдвар (COVID-19)-ын үед Арвайхээр суманд ор дэлгэх тусгаарлах эмнэлгийн тодотгол төлөвлөлтийг хавсралтаар баталсугай.

2. Тусгаарлах эмнэлэг, бэлэн байдлыг хангуулж, төлөвлөлтийн дагуу шат дараатай арга хэмжээ авч ажиллахыг Арвайхээр сумын Засаг дарга, Бүсийн оношилгоо эмчилгээний төв (Э.Хүдэрчулуун)-д тус тус даалгасугай.

3. Тусгаарлах эмнэлэг, ажиллах эмч, эмнэлгийн мэргэжилтэн, холбогдох бусад ажилтнуудыг томилох, ажиллах нөхцөл болон сэтгэлзүйн бэлтгэлийг хангуулахыг сумын Засаг дарга, эрүүл мэндийн байгууллагын дарга нарт даалгасугай.

4. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн ачааалал хэтэрсэн тохиолдолд Коронавируст халдвар (COVID-19)-ийг эмчлэхээр хавсралтад заасан эмнэлэгүүдэд ор дэлгэх, гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудыг шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хувцас хэрэгсэл, ариутгал, халдваргүйтгэлийн бодисоор тасралтгүй хангах, үнийн хөөрөгдөл үүсгэхгүй байх зохицуулалт хийж ажиллахыг сумдын Засаг дарга, Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв)-д үүрэг болгосугай.

5. Коронавируст халдвар (COVID-19)-ийн үед нэмэлтээр дэлгэж байгаа Политехникийн коллежийн дотуур байр, Ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн дотуур байрыг 2021 оны 08 дугаар сарын 23-аас хойш тусгаарлах эмнэлгийн зориулалтаар ашиглахгүй байхыг Арвайхээр сумын засаг дарга (О.Ганбат)-д даалгасугай.

6. Шаардагдах санхүүжилтийг шийдвэрлэхийг аймгийн Засаг Даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Б.Идэрсайхан)-т, сумдын онцгой комиссын дарга нарт зөвшөөрсүгэй.

7. Захирамжийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (И.Доржсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

А.ИШДОРЖ

011100830

Аймгийн Засаг даргын 2021 оны ...08..
дугаар сарын ...19...-ны өдрийн .../2021... дугаар
захирамжийн хавсралт

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (COVID-19)-ЫН ҮЕД АРВАЙХЭЭР СУМАНД
ОР ДЭЛГЭХ ТУСГААРЛАХ ЭМНЭЛГИЙН ТОДОТГОСОН ТӨЛӨВЛӨЛТ

№	Эмнэлэг, тасаг нэгжийн нэр	Өрөөний тоо	Нийт орны тоо		Бие засах газартай өрөөний тоо	Гар угаалтууртай өрөөний тоо
			Энгийн ор	Эрчимт эмчилгээний ор		
1.	Халдвартын тасаг	12	24	1	7	6
2.	Сүрьеэгийн тасаг	6	14	1	-	-
3.	Уламжлалтын тасаг	12	25	-	-	-
4.	Чих, хамар хоолойн тасаг	6	15	-	-	-
5.	Мэдрэлийн тасаг	8	22	3	-	-
6.	Дотор арьсны клиник	15	40	2	-	-
Нийт		76	140	7	-	-

ТУСГААРЛАН АЖИГЛАХ ЭМНЭЛГИЙН НЭМЭЛТ ОР ДЭЛГЭХ БАЙРНЫ ТӨЛӨВЛӨЛТ

№	Тусгаарлах объект	Өрөөний тоо	Дэлгэн ажиллах орны тоо, нөөц	Бие газартай өрөө	Гар угаалтууртай өрөө
1.	Политехникийн коллежийн дотуур байр	44	100	4	6
2.	Ерөнхий боловсролын 1-дүгээр сургуулийн дотуур байр	17	100	4	3

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (COVID-19)-ЫН ҮЕД ХУВИЙН ХЭВШЛИЙН
ЭМНЭЛГИЙН ОРНЫ ТӨЛӨВЛӨЛТ

№	Эмнэлэг, тасаг нэгжийн нэр	Өрөөний тоо	Нийт орны тоо		Бие засах газартай өрөөний тоо	Гар угаалтууртай өрөөний тоо
			Энгийн ор	Эрчимт эмчилгээний ор		
1.	Ариунсанаа эмнэлэг	12	26	2	4	12
2.	Чинмэнд эмнэлэг	11	20	1	1	1
Нийт		23	46	3	5	13